


ҮНДСЭН МЭРГЭШИЛ /РЕЗИДЕНТ/-ИЙН СУРГАЛТЫН 2022-2023 ОНЫ НЭМЭЛТ ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЗААВАР

Зорилго:

Үндсэн мэргэшлийн сургалтын 2022-2023 оны нэмэлт элсэлтийн шалгалтыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.



Бүртгэлийн хугацаа:

2022 оны 12-р сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 09-ний өдрийн 15 цаг 00 минут хүртэл үргэлжилнэ. Бүртгэлийн хугацааг сунгах боломжгүй тул та амжиж бүртгүүлээрэй

Бүртгүүлэх хэлбэр:

Зөвхөн <https://hr.hdc.gov.mn> цахим хаягаар бүртгэнэ. Бүртгүүлэх зааврыг “Заавар харах” хэсгээс, нэвтэрч орсон тохиолдолд “Тусламж” хэсгээс харна уу. Бүртгэлтэй эмнэлгийн мэргэжилтэн Зарлал – Шалгалтын зар – Үндсэн мэргэшлийн элсэлт сонголтоор дамжин бүртгүүлэх товчыг дарж хүсэлтээ илгээнэ. Бүртгэлтэй холбоотой түгээмэл асуулт, хариултыг <https://www.youtube.com/watch?v=qc6LHPjnhIQ>, бүртгүүлэх зааврыг <https://www.youtube.com/watch?v=qIJXlhUHUNQ> холбоосоор нэвтэрч бичлэг хэлбэрээр танилцаарай.

Шалгалтын товыг мэдээллэх: Амжилттай бүртгүүлсэн эмчийн шалгалт өгөх өдөр, танхимын хуваарийг 12 дугаар сарын 09-ний өдрийн 18.00 цагт <http://hdc.gov.mn/> цахим хуудас байршуулна. Хэрэв таны нэр шалгалтын хуваарьт байхгүй бол бидэнтэй 11-461529 дугаараар холбогдоорой.

Шалгалтын төлбөр:

1. Шалгалтын төлбөр 10,000 төгрөг бөгөөд төлбөрийг буцаан олгохгүй тул төлбөр төлөхдөө анхааралтай хандана уу.
2. Хүлээн авах банк: Төрийн сан
3. Хүлээн авах байгууллага: Эрүүл мэндийн хөгжлийн төв
4. Зориулалт буюу утга: Үндсэн мэргэшлийн элсэлт /Овог, нэр, регистрийн дугаар/

5. Дансны дугаар 100900020020 /Төлбөрийг банк, интернэт банк болон ЭМХТ-ийн нэг давхарт байрлах автомат машинд төлөх боломжтой/



Анхааруулах нь, ТА:

1. Энэ удаагийн сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтэн нь 21 аймгийн захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр суралцах бөгөөд төгссөний дараа зөвхөн Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон аймгийн нэгдсэн эмнэлэгт гэрээний дагуу 5 жил ажиллах болно.
2. Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн анагаах ухааны боловсрол олгох сургуулийн хүний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, шүдний их эмчийн бакалаврын дипломтой эмнэлгийн мэргэжилтэн, тухайн мэргэшлийн чиглэлд бүртгүүлэх.
3. Эрүүл мэнд, анагаах ухааны бусад чиглэлээр мэргэшүүлэх сургалт болон магистр, докторын сургалтад зэрэг суралцах боломжгүйг та анхаарах.
4. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвөөс хамрагдахгүй байх.
5. Хувийн болон байгууллагын зардлаар суралцах эмнэлгийн мэргэжилтэнд хамаарахгүй байх.
6. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/489 дүгээр тушаалын дагуу үндсэн мэргэшлийн сургалтад 2022 онд шинээр элссэн суралцагчдад хамаарахгүй байх.
7. Эмнэлгийн мэргэжилтэн нь үндсэн мэргэшлийн зөвхөн 1 чиглэлд бүртгүүлэх.



Холбоо барих:

1. Элсэлтийн шалгалтын бүртгэл, төлбөртэй холбоотой асуудлаар: 11-461529 дугаараар холбогдоорой.
2. Сургалтын чиглэл, бусад асуудлаар: 98142485 дугаараар холбогдоорой.
3. Мэдээлэл шинэчлэх асуудлаар: credit@hdc.gov.mn хаягт хандан хариуг хүлээнэ үү.
 - 3.1. Нууц үг сэргээхэд и-мэйлд хариу ирэхгүй тохиолдолд:
credit@hdc.gov.mn и-мэйлд зөвхөн өөрийн и-мэйл хаягаас /yahoo-аас бусад/ НУУЦ ҮГ СЭРГЭЭХ гэж бичээд Овог, Нэр, Регистр, Ургийн овог, Утас, Оршин суугаа аймаг/хот/, сум/дүүрэг/, баг/хороо, хаягаа илгээнэ үү. Мэдээллээ илгээсэн таны нэртэй и-мэйл хаяг, нууц үгээ сэргээж авах хаяг болно.



II. Шалгалтын зохион байгуулалт



Элсэлтийн шалгалтад орох

1. Элсэгч ТА:

- Шалгалт эхлэхээс 40 минутын өмнө ирсэн байна. Хоцорсон тохиолдолд шалгалтад оруулах боломжгүйг харгалзан цагтаа ирээрэй.
- Иргэний үнэмлэх /эх хувь/, дипломын хуулбар, шалгалтын төлбөрийн баримтыг авч ирж бүртгүүлээрэй.
- Зөвхөн ухаалаг төхөөрөмж дээр шалгалт өгөх тул танхимд орохын өмнө дэвтэр, гар утас, зөөврийн компьютер зэрэг эд зүйлсийг цүнхэндээ хийж үлдээгээрэй.
- Шалгалтын байранд байршуулсан дуугүй хөтөчийн дагуу шалгалт өгөх хуваарьт танхимд очно.
- Комиссын гишүүдийн санамсаргүй сонголтоор хуваарилсан ширээнд сууж, шалгалтын зааврыг анхааралтай сонсож, өөрийгөө бэлдээрэй.
- Шалгалтыг 100 сорилоор авах ба 1 сорилд 1 минут ноогдох тул цагаа зөв төлөвлөж, шалгалтаа амжилттай өгөөрэй.
- Шалгалтыг хугацаанаас нь өмнө дууссан тохиолдолд шалгалтын комиссын гишүүнд мэдэгдэж, бусдын анхаарлыг таталгүй танхимаас гарч болно.

2. Бүртгэл хийх гишүүд нь:

- Шалгуулагчийн иргэний үнэмлэх, дипломын хуулбартай тулгалт хийнэ.
- Шалгалт өгөх хуваарьт танхимд орохын өмнө, дэвтэр, гар утас, зөөврийн компьютер, электрон хэрэгсэл зэрэг эд зүйлсийг цүнхэнд нь хийлгүүлж, тусгайлан бэлдсэн ширээн дээр байрлуулна.

3. Шалгалтын комиссын гишүүд нь:

1. Шалгуулагчийн суух ширээг санамсаргүй сонголтоор зааж, суулгана.
2. Дараах зааварчилгааг өгнө. Үүнд:
 - Шалгуулагчийн ширээн дээр ямар нэгэн эд зүйл байж болохгүйг сануулна.
 - Журамд заасны дагуу дараах тохиолдлуудад шалгалтыг хүчингүй болгох талаар анхааруулна. Үүнд:
 - шалгалтын явцад хоёр болон түүнээс дээш удаа сануулга авсан;
 - шалгалтын явцад бусдаас хуулсан, бусдад хуулуулсан, эдгээр үйлдлийг хийхээр завдсан;
 - Шалгалтын явцад хяналт тавина.
 - Шалгалт зохион байгуулсан тухай тэмдэглэлийг бүрэн үйлдэж гарын үсгээр баталгаажуулна.

4. Инженер, техникийн ажилтан нь:

- Шалгалт эхлэхийн өмнө ухаалаг төхөөрөмж ашиглах алхамыг тайлбарлаж өгнө.
- Оролцогчидод дараах зүйлийг анхааруулна. Үүнд:
 - Шалгалт “**Эхлүүлэх**” товч дарснаар шалгалтын цаг тооцогдохыг;
 - Шалгуулагч сорилыг бөглөж дуусаад “**Дуусгах**” товчийг дарахад шалгалтын дүн таблет дээр шууд гарахыг;
 - Ухаалаг төхөөрөмжийг зааврын дагуу зөв ашиглах, гэмтээхгүй байхыг;
 - Ухаалаг төхөөрөмж, сүлжээний асуудалтай холбоотой асуух асуулт гарвал гараа өргөн ээлжлэн асуухыг;
 - Сорилыг бөглөж дуусаагүй үед өөрийн санамсар болгоомжгүйгээс “**Дуусгах**” товчийг дарсан тохиолдолд шалгалт дуусгавар болохыг;
 - Хугацаа дуусахаас өмнө эсхүл заасан хугацаанд сорилыг бөглөж дууссан тохиолдолд таблетыг ширээн дээр үлдээн, танхимыг орхин гарахыг анхааруулна.
 - Техник, сүлжээний асуудлыг шийдвэрлэж өгнө.
 - Шалгалтын системийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангана.

5. **Шалгалттай холбоотой гомдлын шийдвэрлэлт, хүлээх хариуцлага**

Гомдол гаргагч нь бүртгэлтэй холбоотой гомдлыг бүртгэл дууссанаас хойш ажлын гурав хоногт, элсэлтийн шалгалтын явцад гарсан зөрчилтэй холбоотой гомдлыг элсэлтийн шалгалт өгсөнөөс хойш ажлын нэг өдөрт, үнэлгээтэй холбоотой гомдлыг элсэлтийн шалгалтын нэгдсэн дүнг зарласан өдрийн ажлын цагт багтаан, бусад гомдлыг элсэлтийн шалгалт дууссанаас хойш тав хоногийн дотор тус тус Эрүүл мэндийн хөгжлийн төвд бичгээр ирүүлнэ. /ЭМС-ын 2017 оны 337 дугаар тушаалын 15.19/

6. **Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх**

Элсэлтийн шалгалтыг танхимд, гадаад интернет орчноос тусгаарласан байдлаар планетаар зохион байгуулна. Иймд элсэгчид аливаа нэгэн байгууллага, албан тушаалтны нэр барьж иргэдээс эд хөрөнгө, мөнгө авах залилангийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлж Авилгатай тэмцэх газрын 110 утас болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 70128804 утсанд мэдэгдэнэ үү.